

**УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР**  
**ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТЭС**



**2024 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН**  
**ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

**2024 он**

# ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН 2024 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2024 оны 06 дүгээр сарын 03

Сүмбэр сум

## **НЭГ. Удирдлага зохион байгуулалтын чиглэлээр:**

Говьсүмбэр аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс нь Монгол улсын Үндсэн хууль, Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Иргэний улсын бүртгэлийн тухай хууль, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хууль, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль, Захиргааны ерөнхий хууль, Төрийн албаны тухай хууль, Гэр бүлийн тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль болон Улсын Их Хурал, Засгийн газрын тогтоол, ХЗДХЯам, УБЕГ-аас гаргасан шийдвэрүүдийг хэрэгжүүлэхийн зэрэгцээ УБЕГ-ын 2024 оныг “Хууль хэрэгжүүлэх, хамтын ажиллагааны жил” зорилгыг ханган, өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдлөг болгож байна.

Тус хэлтэс нь хэлтсийн дарга 1, тасгийн дарга бөгөөд улсын улсын ахлах бүртгэгч 2, хяналтын улсын байцаагч 1, улсын бүртгэгч 6, ерөнхий нягтлан бодогч 1, архив, бичиг хэргийн эрхлэгч, нярав 1, мэдээлэл технологийн ажилтан 1, архивч 1, гэрээт ажилтан 5 (үйлчлэгч 1, жижүүр 4) тус тус ажиллахаас хагас жилийн байдлаар 18 албан хаагчийн бүрэлдэхүүнтэй төрийн бүртгэлийн үйл ажиллагааг хэвийн жигд явуулж байна.

Албан хаагчдын ээлжийн амралтын хуваарийг баталсан бөгөөд хагас жилийн байдлаар ээлжийн амралтаа авсан албан хаагч байхгүй байна.

Хэлтсийн “Гүйцэтгэлийн төлөвлөгөө”-г хугацаанд нь боловсруулж, Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга, аймгийн Засаг даргаар тус тус батлуулан, хэрэгжилтийг нь хангах ажлыг зохион байгуулж байна. Мөн ажилтнуудын “Гүйцэтгэлийн төлөвлөгөө”-г батлаж, гүйцэтгэлд нь хяналт тавьж, мэргэжил арга зүйгээр ханган ажиллаж байна.

Тайлангийн хугацаанд хэлтсийн нийт албан хаагчдын хурлыг 14 удаа зохион байгуулсан бөгөөд хурлаар өнгөрсөн хугацаанд хийсэн ажлаа дүгнэж, цаашид хийх ажлаа зөвлөлдөж, тодорхой шийдвэрүүд гаргаж хэрэгжүүлдэг болно. Мөн хууль, тогтоомж, дүрэм журам, судалж танилцах, удирдлагаас өгсөн үүрэг даалгаварын биелэлт, ажилтнуудын сахилга хариуцлага ёс зүй, харилцаа, хандлагыг дээшлүүлэх асуудлуудаар заавар, чиглэл өгч, хурлын тэмдэглэл хөтөлдөг болно. Энэ хугацаанд сахилгын зөрчил гаргасан албан хаагч байхгүй болно.

Улсын бүртгэлийн хэлтэс нь аймгийн Цагдаагийн хэлтсийн хуучин байр болох 1971 онд ашиглалтанд орсон 100,5 м/кв талбайтай, өргөтгөл нь 2008 онд ашиглалтанд орсон нийт 506,94 м/кв талбайтай байранд урсгал засвар хийж, 2023 оны02 дугаар сараар үйл ажиллагаа явуулж байгаа ба ажлын байранд засвар хийгдээгүй, үйлчилгээний зардалд гэрэл шатах, гадна талын пасад салхинд хуурах зэрэг зардалд 2376,7 мянган төгрөг зарцуулаад байна.

Эхний хагас жилийн байдлаар үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийн маргаантай Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд холбогдолтой хэрэгт хариуцагчаар оролцож байгаа бөгөөд нэхэмжлэлийг гардан аваад байна.

Хэлтсийн лавлах 70541890, 70543056 утсанд иргэн, хуулийн этгээдээс 2692 дуудлага хүлээн авч, лавлагаа, мэдээллээр ханган тухай бүрд нь шийдвэрлэв. Эхний хагас жилийн байдлаар Засгийн газрын 1111 төвд тус хэлтэстэй холбоотой гомдол, санал ирээгүй болно.

## ХОЁР. Үндсэн үйл ажиллагааны чиглэлээр:

### а) Иргэний улсын бүртгэлийн талаар:

Д/д	Бүртгэлийн төрөл	(05-р сарын 15-ны өдөр буюу хагас жилийн байдлаар)	
		2023 он	2024 он
1.	Төрсний бүртгэл	156	121
2.	Гэрлэлт	21	26
3.	Гэрлэлт дуусгавар болсны бүртгэл	10	10
4.	Гэрлэлт сэргээлт	0	0
5.	Үрчлэлт	3	4
6.	Эцэг тогтоолт	2	6
7.	Овог, эцэг /эх/-ийн нэр, нэр өөрчлөлт	5	8
8.	Регистрийн дугаар өөрчлөлт	0	2
9.	Нас барсны бүртгэл	31	44
10.	Аймаг, хотоос шилжин ирсэн	117	322
11.	Аймаг доторх шилжилт хөдөлгөөн	162	166
12.	Иргэний шинэчилсэн бүртгэл	118	155
13.	25,45 насны сунгалт	208	195
14.	Иргэний үнэмлэх дахин олголт	89	81
15.	Лавлагаа	1116	2620
16.	Гадаад паспорт /цахим/	224	1042
17.	Гадаад паспорт /энгийн/	672	22
18.	Үйлчилгээний хураамж	46880300	90900000
19.	Тэмдэгтийн хураамж	2306100	6873300
<b>Нийт бүртгэлийн тоо</b>		<b>2895</b>	<b>4940</b>

### б) Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн талаар

Д/д	Бүртгэлийн төрөл	(5-р сарын байдлаар)	
		2023 он	2024 он
<b>Нийт бүртгэлийн тоо</b>		<b>1482</b>	<b>1063</b>
1.	Төрөөс хувьчилсан газар өмчлөх эрхийн бүртгэл	105	36
2.	Газар эзэмших, ашиглах эрхийн бүртгэл	103	40
3.	Газраас бусад үл хөдлөх хөрөнгийн анхны бүртгэл	24	50
4.	Худалдах худалдан авах гэрээ	202	149

5.	Бэлэглэх гэрээ	41	21
6.	Арилжих гэрээ	4	
7.	Өв залгамжлал	19	15
8.	Шүүхийн шийдвэрээр өмчлөгч өөрчлөгдөх		3
9.	Хамтран өмчлөгч өөрчлөгдөх бүртгэл	14	5
10.	Барьцаат зээлийн гэрээ	436	332
11.	Барьцааны гэрээ дуусгавар болсон	405	324
12.	Бүртгэлд өөрчлөлт орсон	46	34
13.	Урьдчилсан тэмдэглэл	30	6
14.	Лавлагаа хуулбар	52	46
15.	Хувийн хэрэг хаасан	1	2
16.	<b>Үйлчилгээний хөлс</b>	<b>11,989,496</b>	<b>11,590,998</b>
17.	<b>Тэмдэгтийн хураамж</b>	<b>87,962</b>	<b>400,800</b>
18.	<b>Татварын орлого (2 хувь)</b>	<b>101,702,572</b>	<b>87,786,751</b>

Эд хөрөнгийн болон хуулийн этгээдийн улсын бүртгэгч нь хуулинд эрх зүйч мэргэжилтэй байхаар зохицуулагдсан байх тул өнөөдрийн байдлаар Баянтал, Шивээговь сумдад ажиллаж байгаа улсын бүртгэгч нар дээрх шаардлагыг хангаагүй байна. Харин иргэдэд бүртгэлийн үйлчилгээг түргэн шуурхай үзүүлэх үүднээс сумдад газрын анхны бүртгэлийн мэдүүлгийг хүлээн авч, бүртгэх үйл ажиллагааг зохион байгуулан ажиллаж байна.

**в) Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн талаар**

Д/д	Бүртгэлийн төрөл	(5-р сарын байдлаар)	
		2023 он	2024 он
1.	ХХК	15	9
2.	ТББ	1	2
3.	Хоршоо		
4.	Үйлдвэрчний эвлэлийн байгууллага	1	1
5.	Шилжиж ирсэн	2	1
6.	Хуулийн этгээдийн салбар	3	1
7.	Хуулийн этгээдийн өөрчлөлт	38	35
8.	Дахин гэрчилгээ шинээр авсан	18	15
9.	Хуулийн этгээдийн нэрийн баталгаажуулалт хийсэн	39	26
10.	Хураасан тамга тэмдэг	2	6
11.	Тамга тэмдгийн хяналтын хуудас олголт	25	26
12.	Лавлагаа	6	
13.	Хориг тавьсан		
14.	<b>НИЙТ</b>	<b>150</b>	<b>122</b>
15.	<b>Тэмдэгтийн хураамжийн дүн (төгрөг)</b>	<b>3,442,000</b>	<b>2,876,000</b>

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр е-монголиа цахим бүртгэлийн системээр ирүүлсэн нийт 211 хүсэлтийг хуулийн хугацаанд хүлээн авч, 8 бүртгэлийг баталгаажуулж, 203 бүртгэлд журмын дагуу татгалзсан хариуг өгч ажилласан байна.

## **ГУРАВ. Архив, албан бичиг хөтлөлтийн чиглэлээр:**

Эхний хагас жилийн байдлаар иргэн, эд хөрөнгө, хуулийн этгээдийн нийт 2956 улсын бүртгэлийн эх нотлох баримт болон цахим бүртгэлд холбогдох баяжилтыг хийгээд байна. Үүнд:

- ❖ Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн 1585 хувийн хэрэгт,
- ❖ Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн 120 хувийн хэрэгт,
- ❖ Иргэний улсын бүртгэлийн 1251 хувийн хэрэгт тус тус баяжилтыг хийсэн болно.

Аймаг, нийслэл рүү шилжин явсан 23 иргэний хувийн хэргийг зохих журмын дагуу холбогдох аймаг газруудад нь шилжүүлсэн.

Мөн байгууллагын архивт байнга хадгалах 90, түр хадгалах 446, 70 жил хадгалах 41 нийт 577 хадгаламжийн нэгж тус тус хадгалагдаж байна.

Тайлангийн хугацаанд Шүүх, Прокурор, Цагдаа, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар болон бусад төрийн байгууллагын хүсэлтээр нийт 2740 лавлагаа мэдээллийг цаг хугацаанд нь хүргүүлсэн болно. Үүнд:

- Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр иргэнд-831, албан хэрэгцээнд-1675, хууль хяналтын байгууллагад-122 нийт-2628,

- Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр эрх түдгэлзүүлсэн 46, эрх сэргээсэн 26, лавлагаа 28, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны хөрөнгийн багцыг тусгай тэмдэглэл хийж бүртгэсэн 4, нийт 104,

-Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр 8 тус тус болно.

Мөн Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газарт улирал бүр ажлын байрыг нэмэгдүүлэх зорилгоор шинээр байгуулагдсан хуулийн этгээдийн судалгааг гарган өгч хамтран ажиллаж байна.

“24/7” цахим үйлчилгээг хэлтсийн 1 давхарт байршуулан нээлтийг хийн хэвийн ажиллаж байна. Иргэнд цаг хугацаанаас үл хамааран ажлын бус өдөр, ажлын бус цагаар буюу хүссэн үедээ 24 цагаар ажиллах энэхүү машинаас үйлчилгээ авч байна. 1500 гаруй иргэн лавлагаа, мэдээлэл “24/7” цахим үйлчилгээнээс авсан байна.

e-Mongolia цахим мэдээллийн сангаас нийт 22 төрийн байгууллагын 155 нэр төрлийн лавлагаа (Улсын бүртгэлийн байгууллагын 23 лавлагаа) мэдээллийг иргэн өөрийн нэр дээр бүртгэлтэй утасны дугаар болон тоон гарын үсгээрээ дамжуулан цаг хугацаа, орон зайнаас үл хамааран үнэ төлбөргүй авах боломжтой болсон бөгөөд иргэдэд өдөр бүр цахимаар хэрхэн лавлагаа авахыг сурталчлан ажиллав.

Архивын өрөөнд 3, архивын үүдэнд 2, архивын өрөөны гадна талд 3 камерийг тус тус байршуулж, 24 цагийн харуул хамгаалтаар хянаж байна.

Архивын аюулгүй байдлыг хангах үүднээс хяналтын камер, агаарын даралт, чийгшил хэмжих зориулалтын багаж, цэнэг бүхий галын хор, хүрз, тармуур, элс зэргийг байрлуулав. Мөн архивын өрөө тасалгааг хортон шавж, мэрэгчээс бүрэн хамгаалахын тулд мэргэжлийн байгууллагаар 2024 оны 3 дугаар сард хортон шавж устгах ажлыг зохион байгуулав.

Хадгаламжин санд нийт 20 удаа чийгтэй цэвэрлэгээ 10 удаа хувийн хэргийн тавиур, хайрцагны тоосыг цэвэрлэж, чийг дулааныг 7 хоногт 3 удаа хэмжин тэмдэглэн хөтлөн хадгалагдаж, хувийн хэргийн аюулгүй байдлыг хангаж ажиллаж байна.

Байгууллагын зүгээс хадгаламжийн сангийн нөхцлийг сайжруулах зорилгоор 460,000 төгрөгийн өртөг бүхий архивын шат, 2 ширхэг галын хор авч байршуулсан.

### **ДӨРӨВ. Албан бичиг хөтлөлтийн чиглэлээр**

Улсын бүртгэлийн ерөнхий газраас баталсан хуваарийн дагуу сар, улирлын улсын бүртгэлийн үйлчилгээний тоон мэдээ, тайлан, үнэт цаасны зарцуулалтын тайлан тооцоог хугацаанд нь үнэн зөв гарган хүргүүлж, баталгаажуулж хэвшсэн.

2024 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар нийт 50 өргөдлийг зохих журмын дагуу бүртгэж, үүний 32 өргөдөл нь албан хаагчдаас, 18 өргөдөл нь иргэдээс ирсэн байна. Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн мэдээг улирал, сараар гаргаж УБЕГ, аймгийн ЗДТГ -т хүргүүлж байна.

Нийт 49 өргөдлийг хугацаанд нь бүрэн шийдвэрлэж, 1 өргөдөл шийдвэрлэх шатанд явж байна. Өргөдөл гомдлын шийдвэрлэлт **98** хувьтай байна.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын Бодлого, төлөвлөлт, дүн шинжилгээний газраас “Улсын бүртгэлийн байгууллагад 2024 оны 1-р улирлын өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн байдалд хяналт-шинжилгээ хийсэн бөгөөд үйл ажиллагааг сайжруулах зорилгоор ирүүлсэн зөвлөмжийн биелэлтийг 04 дүгээр сарын 29-нд гаргаж албан бичгээр хүргүүлсэн.

Тус хэлтэст 2024 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар бусад байгууллагаас 295 албан бичиг ирсэн байна. Хугацаатай 93 бичгийн хариуг хүргүүлсэн байна. Тус хэлтсээс 228 албан бичгийг явуулсан байна.

Хэлтсийн даргын А тушаал-13, Б тушаал-4 нийт 17 тушаалыг зохих журмын дагуу гаргаж албажуулж, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.

Улсын бүртгэлийн ерөнхий газраас цахим [/govisumber@burtgel.gov.mn/](mailto:govisumber@burtgel.gov.mn), [21aimag@burtgel.gov.mn/](mailto:21aimag@burtgel.gov.mn/) хаягаар 224 дотоод албан бичиг, “ЕДОС” архивын албан хэрэг хөтлөлтийн системээр 257 бичиг ирж, 119 бичгийг тоон гарыг үсгээр баталгуужуулан явуулсан байна. Аймгийн байгууллагуудтай “ERP” төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн системийг ашиглан 102 бичгийг хүлээн авч, 41 бичгийг явуулсан байна.

УБЕГ-аас иргэн, эд хөрөнгө, хуулийн этгээд, хяналт, архивын чиглэлээр ирүүлсэн 22 чиглэлийг бүртгэл хяналтанд авч, хэрэгжилтийг хангах ажлыг шуурхай зохион байгуулж ажиллалаа.

-Хэлтсийн даргын 2022 оны А/13 дугаартай “Хэвлэмэл хуудас индексжүүлсэн тухай” тушаалын дагуу хэвлэмэл хуудасны хадгалалт, хамгаалалт, зарцуулалтанд хяналт тавьж, бүртгэл хөтлөж байна.

- Дээд газраас ирүүлсэн албан бичиг, чиглэлийн дагуу холбогдох тайлан мэдээ, судалгааг тухай бүр хугацаанд нь гарган хүргүүлэв.

## **ТАВ. Бүртгэлийн хяналт шалгалтын чиглэлээр**

Тайлант хугацаанд иргэн, эд хөрөнгө, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт шалгалтыг 14 удаа хийсэн. Үүнд:

- ❖ Гүйцэтгэлийн шалгалт-2
- ❖ Гэнэтийн болон төлөвлөгөөт бус-.1
- ❖ Өргөдөл, гомдлын мөрөөр-11

Байнгын болон түүвэрчилсэн шалгалтаар нийт 512 бүртгэлд хяналт шалгалт хийсэн. Нийт эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр 183, иргэний улсын бүртгэлийн чиглэлээр 297, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр 21, архивын чиглэлээр 11 бүртгэлд хяналт шалгалтыг тус тус хийсэн байна.

Улсын бүртгэгчийн алдаатай 19 зөрчлийг илрүүлж, зөрчил гаргасан улсын бүртгэгчид зөрчлийн тэмдэглэл үйлдсэн болно.

Иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санд буруу бүртгэгдсэн болон дутуу мэдээлэл орсон, мэдээлэл байхгүй 10, бүртгэл хүчингүй болгосон 4, регистрийн дугаар өөрчилсөн 1, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээ хаяж, үрэгдүүлсэн 5, нийт 20 дүгнэлт үйлдэж, зөрчлийг арилгасан.

Зөрчлийн тухай хуулиар торгох шийтгэл оногдуулсан 44 иргэнийг 940,000 төгрөг, 1 аж ахуйн нэгжийг 500,000 төгрөг, нийт 1,440,000 төгрөгөөр журмын дагуу торгосон байна. Зөрчлийг зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны дагуу хялбаршуулсан журмаар шийдвэрлэж, аймгийн Прокурорын газарт тухай бүр нь хянуулсан.

Улсын бүртгэл хөтлөх үйл ажиллагаанд хяналт тавьж, улсын бүртгэгч нарт мэргэжил арга зүйн заавар зөвлөгөөг хэлтсийн дарга, хяналтын улсын байцаагч, улсын ахлах бүртгэгчээс өгч, бүртгэлийн үйл ажиллагаанд тогтмол хяналт тавин ажиллаж байна.

Гэрчилгээ, үнэт цаасны зарцуулалтад сар бүр тогтмол хяналт тавьж, хүчингүй болсон үнэт цаасыг улсын бүртгэлийн хэлтсийн өмч хамгаалах комиссоор шийдвэрлүүлсэн. Үнэт цаас хүчингүй болгосон улсын бүртгэгч нарт алдаа гаргахгүй ажиллах талаар заавар зөвлөмж өгсөн.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын Хяналт шалгалтын газраас 2024 оны 04-р сарын 15-ны өдөр 6/4965 албан бичгээр ирүүлсэн үүрэг даалгаварын дагуу 2 удаа шилжилт хөдөлгөөний бүртгэлд шалгалт хийн илтгэх хуудсыг хугацаанд нь хүргүүлсэн байна. Тус хяналт шалгалтаар илэрсэн алдаа, зөрчил байхгүй болно.

Цаашид улсын бүртгэгч нарт бүртгэлийн алдаа, зөрчил гаргахгүй байх тал дээр байнгын хяналт тавьж ажиллаж байна.

## **ЗУРГАА. Төсөв, санхүүгийн чиглэлээр:**

Тайлангийн хугацаанд нийт 502.537.400 төгрөгийн санхүүжилтээс 05-р сарын байдлаар 229.271.200 төгрөгний санхүүжилт хийгдэж, 226.952.667 төгрөг зарцуулаад байна. Өглөг урсгал засварын зардал болон бичиг хэргийн материалд үүссэн болно. 2023 оны Санхүүгийн Аудитаар өөрчлөлтгүй дүгнэгдсэн.



Хэлтсийн үндсэн болон эргэлтийн хөрөнгө, батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, улирлын санхүүгийн тайлан мэдээг Улсын бүртгэлийн ерөнхий газарт PDF болон файлаар хугацаанд нь хүргүүлсэн бөгөөд Улсын бүртгэлийн ерөнхий газарт 5-р сарын 25-ны өдрийн байдлаар 4.093.466 төгрөгийг төвлөрүүлээд байна.

Шилэн дансны тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. 2024 онд нийт 171 мэдээ оруулахаас 05-р сарын байдлаар шилэн дансанд 72 мэдээ мэдээллийг хугацаанд нь байршуулсан бөгөөд хугацаа хожимдуулж мэдээлэл байхгүй. 99 мэдээлэл хугацаа болоогүй хүлээгдэж байна.

Санхүүгийн тайлан, мэдээг Улсын бүртгэлийн ерөнхий газарт PDF файлаар сар, улирлын мэдээг хугацаанд нь хүргүүлсэн. Хугацаа хоцроогүй болно.

Бичиг хэрэг болон шатахуун худалдан авахдаа холбогдох газруудаас үнийн санал авч, хамгийн бага үнийн дүнтэй газартай гэрээ байгуулан худалдан авалтыг хийж байна. Тайлант хугацаанд “Анар үйлс” ХХК-иас 1.080.300 төгрөгийн бичиг хэргийн хэрэгсэл, “Сод монгол” ХХК-иас 630.000 төгрөгийн шатахууны худалдан авалтыг тус тус хийж, зохих журмын дагуу авч тайланд тусгаад байна.

Хэлтсийн туслах аж ахуйн 29 толгой малаас албан хэрэгцээнд 2 толгой малыг зарцуулсан байна.

#### **ДОЛОО. Орон нутгийн удирдлага, бусад байгууллагатай хамтран ажилласан талаар:**

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Засаг дарга болон төрийн бусад байгууллагуудаас зохион байгуулсан олон нийтийн хамаарал бүхий бүхий л үйл ажиллагаанд идэвхитэй оролцож, шаардлагатай тайлан мэдээ судалгааг хугацаанд нь гарган өгч ажиллаж байна.

Аймаг орон нутгийн удирдлагад “Гэрэгэ киоск” ХХК-ийн бүтээгдэхүүн “**Хурдан пос**”, мөн гадна хашаа хаалга хийлгэхэд шаардлагатай санхүүгийн дэмжлэг хүссэн албан бичгийг хүргүүлээд байгаа ба одоогоор шийдвэрлэгээгүй байна.

Монголын Хуульчдын холбооны Говьсүмбэр аймаг дахь салбар, Говьсүмбэр аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль эрх зүйн хэлтэстэй хамтран нийгмийн хариуцлагын хүрээнд жил бүрийн 5 дугаар сарын 01-ний өдөр зохион байгуулдаг “ХУУЛЬЧИЙН ПРО БОНО” өдөрлөгт хэлтсээс 5 албан хаагч оролцож, нийт 37 иргэнд хууль тогтоомжийг сурталчилж ажиллав.





2024.04.29-ний өдөр Говьсүмбэр аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх 425 дугаар нээлттэй хорих ангид ажиллаж хорих ял эдлэж байгаа 11 хүмүүжигчид гэрлэлтийн болон иргэний үнэмлэхийн хугацаа сунгалт, шинээр олголтын үйлчилгээг үзүүлсэн.



Аймаг, нийслэл, сум дүүргийн ИТХ-ын 2024 оны ээлжит сонгуулиар Улсын бүртгэлийн байгууллагын хэрэгжүүлэх үйл ажиллагааны ерөнхий төлөвлөгөөний дагуу Сүмбэр, Баянтал, Шивээговь сумдын ИТХ-ийн Сонгуулийн хэсэг, нутаг дэвсгэр, төвийг байгуулах тухай тогтоолыг хүлээн авч election.gasr.mn хаягт шивж оруулан УБЕГ-ын Иргэний бүртгэлийн газарт эх хувийг хугацаанд нь хүргүүлж ажиллаад байна. Мөн election.gasr.mn хаягт санал авах байрыг, хаягийн хамт ИТХ-ын тогтоолтой тулган шивж оруулсан.

Аймгаас зохион байгуулсан 2 удаагийн Төрийн жинхэнэ албаны шалгалтад тус хэлтсээс 2 бүртгэгч ажиллсан ба алдаа зөрчил гараагүй болно.

Эхний хагас жилийн байдлаар 149 худалдах худалдан авах гэрээний бүртгэлийг хуулийн дагуу бүртгэх, Татварын байгууллагад бүртгүүлэн 2 хувийн татварын нэхэмжлэл үүсгэх ажлыг зохион байгуулав. Тайлант хугацаанд үл хөдлөх худалдан борлуулсны 87.786.751 төгрөгийг орон нутагт төвлөрүүлсэн байна. Мөн байгууллагын санхүүгийн тайлан мэдээг хугацаанд нь цахимаар хүргүүлж хэвшээд байна.

“Нэг өрх-нэг ажлын байр” арга хэмжээний хүрээнд байгууллагад хуваарилагдсан өрх болох Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын харъяат иргэн Чинбатын Ууганцэцэгийн гэр бүлийн 4 гишүүнд тоон гарын үсэг олгож, 03 сард эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах арга хэмжээг хамтран зохион байгуулсан.

Шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд тус хэлтэс нь Мэдээлэл технологийн ажилтны сул орон тоонд Улаанбаатар хотоос Б.Дөлгөөнмөрөнг байнгын ажлын байранд томилон ажиллуулж аймгийн Засаг даргад түрээсийн орон сууцаар хангуулахаар албан бичиг хүргүүлсэн боловч шийдвэрлэгдээгүй байгаа ба тус ажилтан нь Цагдаагийн хэлтсийн түрээсийн байранд түр амьдарч байна. Хэлтсийн албан хаагчдаас 170000 төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.

Мөн 3 албан хаагчийг бусад аймгаас шилжүүлэн томилж түрээсийн байраар хангаж өгөх тухай албан бичиг хүргүүлсэн ч шийдвэрлэгдээгүй байна.

Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй Нотариат, банк, хадгаламж зээлийн хоршоо, банк бус санхүүгийн байгууллага нарын хамтын үйл ажиллагааг

сайжруулах зорилготой хамтарсан уулзалт, зөвлөгөөнийг 2024 оны 03-р сарын 05-ны өдөр зохион байгуулсан ба 15 албан тушаалтан оролцсон.

### **НАЙМ. Идэвх санаачлага, шинэлэг ажлын тайлан**

Хэлтсийн албан хаагчдын үйлчилгээний стандартын хэрэгжилтэнд байнгын хяналт тавьж байна. Үйлчилгээний ил тод байдлыг хангах зорилгоор хэлтсийн ажлын байр, үйлчилгээний танхим болон 3 суманд мэдээллийн самбар, саналын хайрцаг ажиллуулж, 70541890, 70543056 дугаарын утсуудаар мэдээлэл, зөвлөгөөг тогтмол өгч байна.

Улсын бүртгэлийн цахим мэдээллийн сангийн нууцлал, аюулгүй байдлыг тогтмол хянан, программ хангамжийн шинэчилэлийг тогтмол сайжруулан, албан хаагч нарыг дадлагажуулж, өдөр тутмын үйл ажиллагаандаа хэвийн ашиглаж байна. Иргэдээс ирүүлсэн өргөдөл хүсэлтийн дагуу нийт-22 иргэний цахим бүртгэлд нэмэлт өөрчлөлтийг тусгаж, цахим санд бүртгэгдээгүй 11 иргэний нөхөн бүртгэлийг хийсэн байна. Бүртгэлийн үйлчилгээ авахаар ирсэн иргэдийн мэдээллийг нягтлан шалгаж зөрүүтэй орсон болон нотлох баримт цахимжигдаагүй иргэдийн мэдээллийг тухай бүр засч, нотлох баримтыг архивын цаасан баримтаас татан цахимжуулан ажиллаж байна. Тайлант онд иргэний бүртгэлийн чиглэлээр шинээр нийт-1961 бүртгэлийн 4920 нүүр бүртгэлийн маягт, нотлох баримтын хамт цахимжуулсан байна.

2024 оны 04 дүгээр сарын 20-ны өдөр буюу хагас сайн өдөр “Иргэддээ хүрч үйлчилье” уриан дор Иргэний улсын бүртгэлийн, эд хөрөнгийн улсын бүртгэлийн, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн бүх төрлийн үйлчилгээг үзүүлж хэлтсийн нийт албан хаагчид бүрэн бүрэлдэхүүнээрээ ажиллаж иргэний бүртгэлийн чиглэлээр нийт 38 иргэнд үйлчилгээ үзүүлж 50 орчим иргэнд зөвлөгөө мэдээлэл өгсөн бол эд хөрөнгө, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр нийт 13 бүртгэлийг бүртгэж, 34 иргэдэд зөвлөгөө, мэдээллийг өгч ажилласан байна.



Тус хэлтсийн хэмжээнд улсын бүртгэлийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, улсын бүртгэлийн хууль тогтоомжийг сурталчлах, соён гэгээрүүлэх зорилгоор нийт 8 видео контент бэлтгэн иргэдэд цахим болон вэб сайт-д байршуулан түгээсэн. Үүний хүрээнд цахим хуудсаар тус видеонуудад хандсан иргэдийн үзэлт 9600 орчим байна. Тухайлбал: Хэлтсийн дарга З.Баяндугар, аймгийн арслан Т.Пүрэвсүрэн нараар “Иргэний шилжилт хөдөлгөөн”-ний талаар video мэдээлэл бэлтгэн байгууллагын веб сайт болон facebook хуудсанд байршуулсан ба 5400 үзэлттэй байна.

Тоон гарын үсэг олголтын ажлыг эрчимжүүлэх зорилгоор 2024.01.24-ний өдөр тус аймагт үйл ажиллагаа явуулж буй нийт 73 аж ахуй нэгж байгууллагуудад “**Тоон гарын үсгийн талаар ойлголт мэдээлэл**” сургалтыг зохион байгуулж зөөврийн төхөөрөмжөөр тоон гарын үсэг олголтын ажлыг хийх тухай албан бичиг хүргүүлж сургалтын захиалга авч, ажилласан. Буцаж хариу ирүүлсэн 34 байгууллагад сургалт зохион байгуулж зөөврийн төхөөрөмж ашиглан нийт 339 ажилтан, албан хаагчдад тоон гарын үсэг олгосон ба эхний хагас жилийн байдлаар нийт-510 иргэнд тоон гарын үсэг олгосон байна.



2024.05.15-ний өдрийн байдлаар аймгийн хэмжээнд нийт 11659 иргэн хамрагдахаас өссөн дүнгээр 6350 иргэн буюу 54,46% тоон гарын үсэгт хамрагдсан байна.

### **ЕС. Сургалт, сурталчилгааны чиглэлээр**

2024 оны сургалтын үйл ажиллагааны төлөвлөгөөг 5 дэд сэдвийн хүрээнд 18 заалт бүхийн төлөвлөгөөг боловсруулан хэлтсийн даргаар батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Хагас жилийн байдлаар Удирдах ажилтны сургалтад 2 удаа 1 албан хаагч, Мэргэшүүлэх танхимын сургалтад 1 удаа 1 албан хаагч, УБЕГ-аас зохион байгуулсан онлайн 8 удаагийн сургалтад давхардсан тоогоор 48, аймаг, орон нутаг болон танхимын 9 удаагийн сургалтад давхардсан тоогоор 53 албан хаагч тус тус хамрагдсан байна.

Төрийн албаны зөвлөл /ТАЗ/-өөс 7 хоног бүрийн Пүрэв гарагийн 10:00 цагаас төрийн албан хаагчдыг чадавхжуулах “7:4:10” сургалтад 3 удаа давхардсан тоогоор 12 албан хаагч хамрагдсан. Улсын бүртгэгч нар УБЕГ-ын сургалтын системд нэвтрэн тухай бүрт хууль тогтоомжийг судлан, шалгалт өгч мэдлэг чадвараа нэмэгдүүлэн ажиллаж байна.



Архивч Ц.Дүгэрсүрэн нь хувийн зардлаар Архивын ерөнхий газраас зохион байгуулсан “Албан хэрэг хөтлөлт, архивын ажилтан” сэдэвт сургалтад 2024 оны 02 дугаар сарын 14-ний өдрөөс 03 дугаар сарын 14-ний өдрүүдэд хамрагдаж мэргэжлийн үнэмлэхээ авсан.

Монгол бичиг нэвтрүүлэх ажлын хүрээнд Төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллага 2024 оны нэгдүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн крилл, монгол бичгээр хослуулан хөтлөн явуулахтай холбогдуулан өөрсдийн нөөц бололцоондоо тулгуурлан хэлтсийн албан хаагчдад 3 дугаар сарын 11-ны өдрөөс 5 сарын 13-ны өдрийг хүртэлх хугацаанд долоо хоног бүрийн мягмар гаригийн 08:30-10:30 цагийн хооронд нийт 20 цагийн “Монгол бичгийн дунд шат”-ны сургалтыг Сүмбэр сумын 1 дүгээр сургуулийн монгол хэл бичиг, уран зохиолын багш Л.Лоохуузтай хамтран зохион байгууллаа. Сургалтад бүх албан хаагч хамрагдсан бөгөөд сумдын бүртгэгч нар цахимаар оролцов.



Мөн албан хаагчдын унших чадварыг нэмэгдүүлэх зорилгоор үндэсний монгол бичгээр эрхлэн гаргадаг “Хүмүүн бичиг” сониныг 2023 оноос эхлэн тогтмол захиалан уншиж хэвшсэн байна.

Монгол улсын гавьяат багш Н.Түмэн-Өлзийн нэрэмжит Монгол бичгийн говийн бүсийн олимпиадад 4 албан хаагч, өөрсдийн мэдлэг оюунаа сорин амжилттай оролцов.

Албан хэрэг хөтлөлтийг Mongolian Baiti фонтыг ашиглан монгол бичгээр албан бичгийн үйлдэн 2 удаа хүргүүлсэн байна.

### **АРАВ: Бусад зохион байгуулсан ажлын чиглэлээр:**

Говьсүмбэр аймаг байгуулагдсаны 30 жилийн ойг 4 заалт бүхий төлөвлөөг батлуулан 24,500,000 төгрөгний тооцоог гаргаж УБЕГ-ын Санхүү аж ахуйн хэлтэст хөрөнгийг шийдүүлэх 2 удаагийн албан бичгийг хүргүүлсэн, одоогоор төсөв хөрөнгө шийдэгдээгүй байна.

Албан хаагчдын нөөц боломжоор зарим төлөвлөгөөт ажлыг хийгээд байна. Бүтээн байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилт 30 хувьтай явагдаж байна.

Байгууллагын гадна талд 2 гэрэлтүүлэг, хаягжуулалтыг стандартын дагуу хийлгэж байршуулаад байна.

“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд зохион байгуулагдаж буй Говьсүмбэр аймгийн 2024 оны хаврын бүх нийтээр мод тарих арга хэмжээнд тус хэлтсийн 13 албан хаагч, 175,000 төрөгийн 70 ширхэг хайлаас модыг Сум дундын ойн ангийн мод үржүүлгийн талбайд тарьлаа.

2023 онд тарьсан 95 шихэг хайлаас модны сургалт 80% байна.

Байгууллагын мод арчилгааны хуваарьт газарт нөхөж 10 ширхэг /улиас 3ш, шар хуайс 3ш, хайлаас 4ш/ 28,000 төгрөгийн модыг суулгаж, 3 удаагийн цэнэг усалгааг хийж, модыг тогоолох, ойр орчимын хогийг цэвэрлэх ажлыг зохион байгуулсан.



Байгууллагын албан хаагчдад хог хаягдлын менежментийн үйл ажиллагааг сурталчилж, албан хаагчдад хогийг зөв ангилан ялгах, зориулалтын хогийн саванд хаяж байх талаар чиглэл, зөвлөмжийг байнга өгч, хогийг ангилан ялгаж байна. Байгууллагын ойр орчмын 50 м газрын хогийг 14 хоног бүрийн Лхагва гарагт цэвэрлэж, өвлийн улиралд давс цацаж халтиргаа гулгаа үүсэх эрсдэлээс урьдчилан сэргийлж ажилласан ба мэдээллийг “Хоггүй Сүмбэр” фэйсбүүк хаягт тогтмол байршуулан ажиллаж байна. Тайлант хугацаанд 11 удаа хог цэвэрлэж, 2 тонн хогийг ачуулах ажлыг зохион байгуулав.

Байгууллагын албан хаагчдын өглөөний эрч хүч болон бие энергийг сэргээх, хөдөлгөөний дутагдалт орох эрсдлээс урьчилан сэргийлэх үүднээс албан хаагч бүр өөрсдийн санаачлигаар нэгдэн ажлын байрны дасгал хөдөлгөөнд өдөр бүр идэвхитэй хамрагдаж байна. Аймгийн БТСГ-аас зохион байгуулсан өглөөний алхалт, гүйлтэд тус хэлтсийн албан хаагчид бүрэн оролцсон.



Аймгийн Политехникийн коллежтэй долоо хоног бүрийн мягмар гарагт зааланд тоглохоор гэрээ байгуулан 19 удаа зааланд тоглож албан хаагчдыг чийлэгжүүлсэн.

Аймгийн Засаг даргын биеийн тамир спорт, нийтийн эрүүл мэндийг дэмжих арга хэмжээний хүрээнд Биеийн тамир спортын газраас зохион байгуулсан “ӨВЛИЙН АГААР-ӨЛЧИР БИЕ”- цасны баяр 2024 оны 01 дүгээр сарын 26-ны өдөр Хаялга нууран дээр зохион байгуулагдсан ба аймгийн Шүүхийн тамгын газар, Прокурорын газартай хамтран оролцож 3 дугаар байранд шалгарсан.



Тус хэлтэс нь 2023 онд аймгийн “Оны онцлох байгууллага”-аар шалгарч XVII жарны "Хилэнт эх" хэмээх модон Луу жилийн сар шинийн баярын нийтийн золголтын арга хэмжээнд ууц, идээ засаж, иргэдэд айраг, идээгээр үйлчилж хүндэтгэл үзүүлсэн ба байгууллагын харьяалалтай 6 ахмад хүндэтгэл үзүүлэн 979,2000 төгрөгийн мөнгөн тэтгэмж, гарын бэлэг гардуулсан.



Байгаль цаг агаарын онцгой нөхцөлийг богино хугацаанд хохирол багатай даван туулахад малчин түмэндээ тусалж, сэтгэлийн дэм өгөх зорилготой Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлаас санаачилсан “Бид хамтдаа аян”-д нэгдэн 2024 оны 03 дугаар сарын 13-ны өдөр хүн хүч дутмаг Сүмбэр сумын 6 дугаар /Малх баг/ багийн малчин өрх Г.Алтансүх-ийнд очиж хороо бууцны цасыг өөрсдийн боломжид арилган 81,000 төгрөгийн 3 уут хивэг, 179234 төгрөгийн хүнсний тусламжийн дэмжлэг үзүүлсэн ба УБЕГ-аас зохион байгуулсан “Бүртгэлийн илч хандив”-ын аянд 320,000 төгрөг, өөрийн малчинд 300000 төгрөгийн өвс, хивэг, 150,000 төгрөгийн шатахуун, Сүмбэр сумаас зохион байгуулсан “Малчиддаа туслья” аянд 9 нэр төрлийн хүнс, нэмнээ зэрэг 200,000 төгрөгийн эд материалын тусламжийг тус тус үзүүллээ.



Байгаль, зэрлэг ан амьтнаа хамгаалах үйлсийг дэмжин “Сэтгэл шингэсэн нэг боодол өвч аян”-д нэгдэн хаврын эхэн сарын шинийн 15-ны билэгт сайн өдөр хамт олноороо Чойрын богд ууландаа гарч 3 боодол өвсийг аргал янгирт тавьж өгсөн.

Аймгийн Засаг даргын тамгын газар, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын зохион байгуулах салбар зөвлөлөөс төрийн байгууллагуудын албан хаагчдын дунд 2024 оны 05 дугаар сарын 28-ны өдөр “Авилга, ашиг сонирхолын зөрчлөөс урьдчилан сэргийлэх” сэдвийн хүрээнд Карл Попперийн мэтгэлцээний тэмцээнд Хяналтын улсын байцаагч Т.Цэвэлмаа, Иргэний бүртгэлийн тасгийн дарга бөгөөд улсын ахлах бүртгэгч Ч.Бүрэнжаргал, эд хөрөнгөний эрхийн улсын бүртгэгч З.Чагцалмаа нар байгууллагаа төлөөлөн оролцож 4 дүгээр байранд орсон.



Хэлтсийн мэдээлэл технологийн ажилтан тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагааг хангах болон цахим мэдээллийн санд байнгын хяналт тавьж байна. Комьпютер, тоног төхөөрөмжүүдэд 3 удаа засвар, үйлчилгээ хийсэн. Мөн комьпютер болон мэдээллийн санд нэвтрэх нууц кодыг солих зааврыг тухай бүр тогтмол өгдөг болно.

Байгууллагын албан хаагчдыг архи, согтууруулах ундаанаас үүдэлтэй гэмт хэрэг, зөрчилд өртөхөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр ерөнхий газар болон хэлтсийн даргын зүгээс байнгын анхааруулга өгдөг бөгөөд албан байгууллага дотор болон бусад хэлбэрээр архидан согтуурах явдал байхгүй болно.

Албан хаагчдын 2024 оны “Ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны төлөвлөгөө”-г даргаар батлуулж, хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулж, эхний хагас жилийн байдлаар биелэлтийг гаргаж, холбогдох газарт хугацаанд нь хүргүүлэв. Тухайлбал:

-Аймгийн “Энх билэг” хувийн эмнэлэгтэй хамтран эрт илрүүлэгийн шинжилгээнд нийт 19 албан хаагчдыг нас насны ангилалын дагуу хамрагдуулсан. Эрт илрүүлэгт хамрагдснаар 3 албан хаагч хэвтэн эмчлүүлсэн. Өдрийн эмчилгээнд 14 албан хаагч хамрагдсан.

-Эрх зүйч мэргэжлээр суралцаж буй төрийн захиргааны 1 албан хаагчид цалинтай чөлөө олгож 2024 оны 03 дугаар сард төгссөн.

-2023-2024 оны өвөл цас зудтай, өвөлжилт хүндрэлтэй байсантай холбогдуулан мал бүхий өрхийг дэмжин 2 албан хаагчидад 5 өдрийн цалинтай чөлөө олгож, дэмжлэг үзүүлсэн.

-Хэлтсийн даргын 2024 оны “Цалинтай чөлөө олгох тухай” А/08 дугаар тушаалаар албан хаагчдын хүүхдүүдийн төрсөн өдрөөр 1 өдрийн чөлөө олгодог болсон ба 10 албан хаагчид цалинтай чөлөө олгосон байна.

- Албан хаагчдын дунд найрсаг харилцааг бий болгох зорилгоор албан хаагчдын “Төрсөн өдөр”-өөр хамт олны сангаас 360.000 төгрөгийг олгодог бөгөөд хагас жилийн байдлаар нийт 7 албан хаагчдад 2,520.000 төгрөгийг олгов.

-Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах баярын өдрийг тохиолдуулан албан хаагчдын гэр бүлийн дунд “Мөрөөдлийн баяр” өдөрлөгийг зохион байгуулан 500,000 төгрөгийн зарцуулж, 34 хүүхдэд бэлгийг гардуулав.



**ТАЙЛАН БОЛОВСРУУЛСАН:**  
АРХИВ, БИЧИГ ХЭРГИЙН ЭРХЛЭГЧ,  
НЯРАВ В.ГЭРЭЛЧИМЭГ

**ХЯНАСАН:**  
ХЭЛТСИЙН ДАРГА 3.БАЯНДУГАР